

ИРГЭН УЛСЫН ҮЕИЙН МОНГОЛ СОНИН СЭТГҮҮЛИЙН ӨВӨР
МОНГОЛЫН НИЙГЭМ, СОЁЛД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨГ ШИНЖЛЭХ НЬ

Ү.Нарантуяа*

*Хөлөнбуйр Дээд Сургуулийн багш, магистр

Түлхүүр үг: иргэн улс, монгол сонин сэтгүүл, Өвөр монгол орон, үр нөлөө

Агуулгын товч: Иргэн улсын 1932-1945 онд тухайн үеийн улс төрийн хүчнүүд бүх сонин сэтгүүлийг ашиглан өөр өөрийн улс төрийн үзэл ухамсрын талаар ухуулга хийж, ард олны үзлийг өөрчилж, улс төрийн ноёрхлоо бэхжүүлэхийг санаархаж байсан юм. Үүнд сонин сэтгүүлийн ухуулгаас болж, тухайн үеийн нийгэмд ганцаар эзэмшлийн яриа хэлэлцээний орчин тойрныг буй болгож, ардын дундах яриа хэлэлцээ цаашид ард олны үзэл ухамсар, үндэстний соёл дамжуулга, соёл солилцоо зэрэгт цөм бага бусаар нөлөө болж байсан байна. Тус өгүүлэлд иргэн улсын 1932-1945 он хүртэлх цаг хугацаан дахь сонин сэтгүүлийн мэдээлэлд суурилж, тухайн үеийн Өвөр Монгол орны нийгэм соёлд үзүүлсэн үр нөлөөг шинжиллээ.

Нэг. Нийгмийн яриа хэлэлцээн дэх үр нөлөө. Чин улсын төр нурсны сүүлээр монголчууд хэрхэн оршин тогтнох ба Монгол орны гарах замын тухай асуудал бол тухайн үеийн монголчуудын дундах яриа хэлэлцээний гол сэдэв байсан юм. Энэхүү асуудлын тойронд тухайн үеийн Монгол орны язгууртан ван гүн нараас өөрийн эрх ашгаа хамгаалах үүднээс олон талыг

барлаж, эргэлзэн татгалзаж байжээ¹. Нөгөө талаар монголчуудын дундах эрт соён гэгээрсэн бичигтэн сэхээтэн ч үндэстний угсаатнаа хөгжүүлэн мандуулахыг ихэд санааширч, монголчуудын гарах замыг идэвхтэй эрэлхийлж, эл талын нөхцөл боломжийг ашиглан ухуулга тэмцэл өрнүүлж л байсан юм. Хорьдугаар зууны гучаад оноос эхлэн монгол орон түрэмгийлэл болон улс төрийн чанга дарангуйлал эзэмшилд орж, сонин сэтгүүлийн үйлс улс төрийн хүчний ухуулгын багаж болж, нийгмийн яриа хэлэлцээ ганцаар эзэмшилд орсон байна.

1. *Сонин мэдээний эрх чөлөө боомлогдож, ганцаар эзэмшлийн яриа хэлэлцээний орчныг буй болгосон.* ХХ зууны эхний үед Японы эзэрхэг түрэмгийлэл Өвөр Монголын зүүн хойд оронд нэвчилт хийж байсан үед, Японы цэргийн талаас даруй монгол оронд хандуулсан монгол хэлний сонин сэтгүүл эрхэлж төсвийг гаргаж байсан юм. 1916 онд Японы хуурай замын цэргийн штабын төвийн газраас “Зүүн Монголын хэрэг учрын онцгой номер”-т монгол хэлний сонин сэтгүүл хэвлэн тараахын чухал чанар хийгээд эрхлэх бодит төлөвлөгөө тогтоосон байжээ². Төсвийн тойм доорх мэт: тухайн үеийн Өвөр Монголын ван гүн хошууны ард Ар Монголын тусгаарласан нөлөөг хүртэж,

улс төрийн тал нэгэнт гуйвж эхэлжээ. “Монгол хэлний сонин сэтгүүл хэвлэн тарааж, Японы дотночлох үзлийг ухуулж сайн тохиол мөн”. Сэтгүүлийн найруулга хялбар ойлгомжтой байхыг хичээж, япон хүн болон монгол хүний хоорондох арьстан хийгээд шашин суртахууны талаарх адилавар зүйл хийгээд японы соёл боловсныг танилцуулж, монгол хүний дунд бишрэн шүтэх сэтгэлийг буй болгоно. Тэд нарт тариаланг хөгжүүлэх чухал чанарыг ойлгуулахаар харалт болгоно³. Гэвч тухайн үеийн эл зүйлийн шалтгаанаас болж энэхүү төлөвлөгөө нь биелэгдэж чадсангүй.

Хуурмаг Манж улсыг байгуулсны дараа япон эзэрхэг түрэмгийтнээс зүүн хойдын сонин мэдээ, хэвлэлийн үйлсийг бүрмөсөн эзэмшиж, сонин мэдээллийн ноёрхлын системээ алхам алхмаар цогцлоон байгуулжээ. 1932 онд “Манж улсын чимэглэлийн хороо”-г байгуулж, 1935 оны 10 сард Хуурмаг Манж улсын сонин мэдээ чимээ нэвтрүүлэхэд эзэмшил хийдэг тусгай байгууламж болох “Өргөн мэдээллийн нийгэмлэг” байгуулжээ. Сонин сэтгүүлийн талаар “Энх эрдэмтийн сонин сэтгүүл”, “Манжийн өдөр өдрийн сонин сэтгүүл”, “Манжийн сонин сэтгүүл”-ээр дамжин бүхий л зүүн хойд орны сонин мэдээ сураг зангийн ирлийг эзэмшсэн байна. Үүнээс гадна япон эзэрхэг түрэмгийтнээс албаны талын сонин сэтгүүлийг шалавлан эрхэлж, урьд хожид “Хянган ерөнхий балгадын цуглуулсан дармал”, “Монгол сэтгүүл”, “Монгол засгийн зургааны хураангуй дармал”, “Монгол шинэ сэтгүүл”, “Хүүхдийн шинэ сэтгүүл”, “Залуусын толь”, “Номун ханы хэрэг хувьслын зургийн сэтгүүл”, “Хүүхдийн зургийн сэтгүүл”, “Хөх туг”, “Хөх тугийн сүүдрийн арван өдрийн сэтгүүл”, “Их хөх туг”,

“Хянган ерөнхий мужийн албан сэтгүүл” зэрэг арваад сонин сэтгүүл эрхэлжээ. Эдгээр сонин сэтгүүлийн зарим нь засгийн ордны байгууллагын сонин сэтгүүл байж, зарим нь нийгэмлэгээс мөнхүү гарган эрхэлсэн сонин сэтгүүл мөн байж, цөм Японы колонийн ноёрхолд үйлчилдэг сонин сэтгүүл болно. Эдгээр сонин сэтгүүлийг эрхлэхээр дамжин зөвлөлт болон эв хамт намыг эсэргүүцэх, япон монгол эе найрсаг, их дорнод Азийн хамтаар цэцэглэх хүрээлэн, үндэстэн бүгд хамтаар найрамдах, дорно дахины шинэ эмх журмыг байгуулах, японы үзэл суртал зориг санааг бардуулах зэрэг гол сэдвийн тойронд ухуулга хийж яриа хэлэлцээ зохион өрнүүлж байжээ.

1 937 оноос өмнө Өвөр монголын баруун орон Гоминданы Нанжингийн засгийн орон нутгийн засаг болсон Сүйюүван /Хөх хот/ мужийн засгийн ордны хамааралт дор байсан юм. 1927 онд Гоминданы Нанжингийн засгаас Хөх хотыг муж болгон өөрчилөх зарлиг болгож, Хөх хотыг эрхшээлдээ оруулсан байна. Үүний хамтаар “Тэрс-лүү дармалыг байцаан хориглох зарлиг”, “Хэвлэлийн хууль”, “Ухуулгын бодисын хянан байцаах баримжаа”, “Сонин мэдээ хянан байцаах баримжаа” зэрэг сонин мэдээ хэвлэлийн хууль дүрмүүдийг нийтэлж, хэвлэлийн агуулгад нарийн чанга хязгаарлал хийснээс гадна бас сонин сэтгүүл эл шатны намын ухуулах хэлтэст тэмдэглэн данслах, намын төв хорооны ухуулах хэлтэст зөвшөөрөл эрэх хэрэгтэй хэмээн тогтоожээ. Тухайн үед Хөх хотын засгийн ордонд тусгайлан сонин мэдээнд байцаалт хийдэг байгууламж болох “Зар мэдээний дугуйлан” гэж байв. Тус дугуйлангаас өдөр бүрийн сонин мэдээллийн агуулгад байцаалт хийхийг хариуцдаг. 1931 он Пү Зүйвэ Эй

Сүйюүван мужийн тэргүүлэгчийн тушаалд гарснаас баруун орон дахь сонин мэдээ яриа хэлэлцээний эзэмшил харьцангуй сулавтархан байжээ. Гэвч Хөх хотын засгийн ордноос албан сонин сэтгүүл эрхлэх болон ардын дундах сонин сэтгүүлийг илбэн дэмжих арга хэлбэрээр Гоминданы төрийн бодлого, үзэл ухамсрыг ухуулахын хамт бас монголчуудад их Хятадын үзлийн дарангуйлал хийж, монгол сонин сэтгүүл эрхлэхийг хязгаарлаж, монгол орны яриа хэлэлцээг чанга эзэмшиж байсан юм.

1937 онд Өвөр Монголын баруун орон япон эзэрхэг түрэмгийтэнд эзлэгдсэний дараа Хөх хотын засгийн ордон арга буюу баруунш шилжиж, Хөх хотын засгийн төлөөний сонин сэтгүүл ч хамт баруунш шилжиж очсон байна. Үүнд япон эзэрхэг түрэмгийтэн яриа хэлэлцээ ухуулгын талаар мөн нэгдэлтэй эзэмшил хийж, сонин мэдээллийн ганцаар эзэмшлийн байгууламж болох “Монгол хязгаарын шинэ сэтгүүлийн хоршоо”-г байгуулжээ. Тус чимэглэлийн хороо нь хэдийгээр өнгөн талд аж ахуйллын хэлбэрээр илэрсэн боловч үнэндээ Японы тагнуулын байгууламжийн соёлын тагнуул хийдэг зохион байгуулалт болно. Тэр нь хэмжээгээр маш их байж, тухайн үеийн “Манж улсын чимэглэлийн хороо”, Нанжингийн “Дундадын чимэглэлийн хороо”-той хамт Японы эзэлсэн орны гурван том чимэглэлийн хороо бүгд бас гурван том ухуулгын машин болон тагнуулын байгууламж болно.

Монгол хязгаарын шинэ сэтгүүлийн хоршоог байгуулсны дараа япон эзэрхэг түрэмгийтнээс тухайн үе дэх хятад сонин “Монгол хязгаарын өдрийн сэтгүүл” болон “Цахарын шинэ сонин” зэрэг сонинг хамтатган япон хэлний сонин “Монгол хязгаарын сонин мэдээ”,

хятад хэлний сонин “Монгол хязгаарын шинэ сэтгүүл” болон монгол хэлний “Монгол шинэ сэтгүүл”, “Монголын долоон өдрийн сэтгүүл” зэрэг сонин сэтгүүлүүдийг хэвлэн тараажээ. Эдгээр япон эзэрхэг түрэмгийтнээс шууд гар дүрэн эрхэлсэн сонин сэтгүүлээс гадна монгол хязгаарын засагт ажиллаж байсан монголчуудаас сэдэж эрхэлсэн сонин сэтгүүл байдаг. Эдгээр сонин сэтгүүл нь хэдийгээр монголчуудын эрхэлсэн сонин сэтгүүл боловч мөн л япон эзэрхэг түрэмгийтний эзэмшлээс мултартч чадашгүй байж, агуулга хэлбэрийн хувьд мөн японыг дотночлох агуулга хийгээд монгол үндэстний утга соёлыг хөгжүүлэхээр гол болгож байв.

Япон эзэрхэг түрэмгийтний харьяаны сонин сэтгүүл хийгээд Гоминданы хорооны сонин сэтгүүлийг гаргавал, монгол бичигтэн сэхээтнүүд болон монгол залуусын эрхэлсэн сонин сэтгүүл ч тухайн үеийн монгол хэлний сонин сэтгүүлийн чухал нэг тал болж байжээ. Гэтэл энэхүү талын сонин сэтгүүл нь тухайн үе дэх монгол орны ухуулга яриа хэлэлцээнд их үр нөлөө болж чадаагүй байлаа. Учир нь, монгол бичигтэн сэхээтнүүд, монгол залуусын эрхэлж байсан сонин сэтгүүл нь үндсэндээ цөм Бвэйпин /Бээжин/, Япон буюу Нанжин зэрэг их хотод төвлөрч, монгол орноос нэлээд зайтай байж, тараалтын тоо хэмжээ ч цөөн, монгол оронд хүртэл дамжигдах нь цөөхөн байжээ. Нөгөө талаар эдгээр сонин сэтгүүл нь олонх нь цөм нийгмийн тусламж мөнгөнд түшиглэж байснаас нөхцөл тэнхээ хүрэлцэхгүй, хааяа хэвлэл зогсож байсан юм. Бас зарим нь нам бүлгэмийн дэмжлэгийг түшиглэж байсан учраас улс төрийн дайчин чанараар хэцүү болж, нам бүлгэмийн үзэл ухамсар зарлиг зааварт хязгаарлагдаж, улс төрийг өгүүлэхээ байгаад,

зөвхөн үндэстний соёл сурган хүмүүжлийн талаар үлэмж ухуулга хийж байсан юм.

Япон эзэрхэг түрэмгийтэн болон Гоминданы ноёрхлын дарангуйлал хавчлагын доор Монгол орны ард түмний жинхэнэ хүсэл шаардлагыг төлөөлсөн мэдээ зуучлуур устаж, нөгөө талаар сураг зангийн битүүмжлэлээс болж ард түмэн гадаад орчны бодит байдлыг мэдэхгүй болж, худгийн ёроол дахь мэлхий мэт болсон байжээ. Тэмдэглэлийг үндэслэвэл, тухайн үеийн монгол хязгаарын засгийн газрын тэргүүн байсан Дэ ван хийгээд Ли Шёо Шин байтал сураг зангийн битүүмжлэлээс болж, гадаад орчны байдлыг ойлгохгүй, 1945 оны 8 сарын 10 хүртэл япон эзэрхэг түрэмгийтэн бууж өгөхөөр байх байдлыг мэдсэнгүй, мөн л хурал хийж хуурмаг монгол цэргийн өргөтгөлийн асуудлыг ярилцаж, 8 сарын 15-нд япон ялагдаж бууж өгсөн чимээг олоод гэнэтийн дайралтад учирсан мэт гардах ажлаа хаяад санд мэнд гарч зугтаасан байна⁴.

2. *Яриа хэлэлцээ голдуу дөрвөн талд төвлөрсөн.* 1932-1945 оны хоорондох цаг үед Монгол оронд тарааж байсан сонин сэтгүүлд япон манжийн төлөөний сонин сэтгүүл хийгээд Гоминданы төлөөний сонин сэтгүүл голлох байрыг эзэлж байжээ. Япон эзэрхэг түрэмгийтний эзэмшил доор байсан хуурмаг Манж хийгээд монгол хязгаарын засгийн харьяаны сонин сэтгүүлийн ухуулгын гурван тал гэвэл, нэгд колонийн үзэл ухамсар, бодит илрэл нь японы соёл боловсныг танилцуулж, япон цэрэг, япон манжийн үйл ажиллагаа хийгээд төрийн бодлого зэргийг магтан дуулж, их дорнод Азийн хамтаар цэцэглэх үзэл, таван угсаатны хамтаар найрамдах үзлийг ухуулж, япон хэл заан сургах зэрэг болно. Хоёрт, эв

хамт нам ба улаан Зөвлөлтийг эсэргүүцэх ухуулга, бодит илрэл нь голдуу улаан Зөвлөлтийг чөтгөр шуламтай адилхан муушаан мэдээлэн ухуулах. Гуравт, монгол үндэстний соёл боловсныг хөгжүүлэх ухуулга хийсэн. Энэ нь голдуу монгол үндэстний сургууль байгуулж сурган хүмүүжлийг хөгжүүлэх, эрүүл хамгаалал, мухар бишрэл алжуу залхуу зэрэг нийгмийн архаг гэмийг илчлэн ухуулах, утга зохиол нийтлэх, түүх судрын зүйлийг нийтлэх зэрэг агуулга дамжуулгад бодитой илэрч байдаг. Гоминданы төлөөний сонин сонин сэтгүүлийн ухуулга мөн гурван талд төвлөрч байсан. Нэгд, гоминданы намын үзэл, гоминданы төрийн бодлого зэргийг ухуулж, хоёрт, Японы түрэмгийлэл хийгээд Зөвлөлт болон Ар Монголыг эсэргүүцэх, гуравт, монгол үндэстний соёл сурган хүмүүжлийг хөгжүүлэх тухай ухуулах зэрэг болно. Монгол сэхээтнүүд хийгээд монгол залуусын эрхэлж байсан сонин сэтгүүл голдуу монгол үндэстнээ хөгжүүлэх тухай ухуулж байсан нь Японы төлөөний сонин сэтгүүл болон гоминданы төлөөний сонин сэтгүүлтэй үндсэндээ адилавартай байсан юм.

Ерөнхийлөн үзвэл, тухайн үеийн сонин сэтгүүлд ухуулж байсан яриа хэлэлцээ голдуу японы колонийн үзэл ухамсар, гоминданы үзэл ухамсар, Зөвлөлт, Ар Монгол болон эв хамт намыг эсэргүүцэх, монгол үндэстний соёл боловсныг хөгжүүлэх зэрэг агуулгад төвлөрч байв. Үүний дунд монгол үндэстний соёл боловсныг хөгжүүлэх тухай ухуулга нь монгол түмний дунд жинхэнэ үр нөлөө үзүүлж байсан юм. Учир нь энэ нь тухайн үеийн монголчуудын дарлал мөлжлөгөөс мултрах, хөгжин мандах хүсэл шаардлагад нийцэж байсантай шууд холбоотой юм.

Хоёр. Нийгмийн үзэл ухамсар дахь үр нөлөө. Иргэн улсын 1932-1945 оны сонин сэтгүүл хэдийгээр улс төрийн чанараар чанга байсан боловч улс төрийн ухуулгаас гадна монгол үндэстнийг хэрхэн хөгжүүлэх, Монголын түүх шашдир утга соёл, шинжлэх ухаан шинэ мэдлэг зэрэг агуулгуудыг үлэмж мэдээлэн нийтэлж байжээ. Эдгээр агуулга нь тухайн үеийн монгол орны ард түмэнд шинэ мэдлэг, шинэ үзэл санааг дамжуулан өгч, үүний улмаас ард олны үзэл ухамсрыг зохих хэмжээгээр нөлөөлсөн байна.

1. Үндэстэн угсаатнаа хөгжүүлэх хүсэл шаардлагыг чангатгасан. Ойр орчин үе бол Монголын нийгэм харанхуй хоцронгуй байсан цаг үе мөн. Тэр цаг үед монгол ард түмний амьдрал ядуу зүдүү, соёлын хир төвшин доор, монгол язгууртан шашны мяндагтан, феодалын ноёрхогч, эзэрхэг түрэмгийтэн зэрэг олон талын дарлал мөлжлөгийг амсаж байжээ. Үзэл ухамсрын талаар, шашны нөлөөг их хүртэж, эрх тэгш, ардчилал, үндэстэн угсаатан гэх одоочилсон үзэл танилтаар дутмаг байсан юм. Монголын язгууртнууд хэдийгээр эхлэн монгол орны гарах замыг эрэлхийлж байсан боловч, олонх нь илжрэн доройтож, цаг төрийн үймээний дунд зөвхөн өөрийн эрх ашгаа хамгаалахыг л бодож байсан юм. Чин улсын сүүлчийн үеэр Гүнсэнноров чин вангийн эрс өөрчлөлтөөс Монгол

оронд хамгийн анхны шинэ үзэл санааны урьхан салхийг салхилуулсан байна. Мөн ч энэхүү урьхан салхины илбэлт доор монголчуудын соёлын хэр төвшин дээшилж, бичигтэн сэхээтэн аажмаар олширч, үндэстэн угсаатнаа хөгжүүлэх үзэл ухамсар аажмаар соёолж эхэлсэн байжээ.

Монголоо хөгжүүлэн мандуулах тухай ухуулга нь хорьдугаар зууны арваад оны сүүлч хориод оны эхний үеэр анх эхлэн сонин сэтгүүлд илэрсэн байна. XX зууны эхний үед япончуудаас Манж, Монгол оронд нэвчилтийн ажиллагаа хийж байсан үед даруй “Манж Монголын тухай бодлого”-ыг дурдаж, 1918 онд хэвлэгдсэн “Мүгдэний монгол сэтгүүл”-ээр ухуулга хийж байсан юм. Тус сэтгүүлд монголчууд буурай дорой болсон учир шалтгааны тухай, монгол хүн хатуужин чармайх тухай өгүүлэн шүүмжилж байжээ.

Монголоо хөгжүүлэх үзлийн ухуулга нь XX зууны гучаад оны эхнээс дөчөөд оны дунд хүртэлх хугацаанд анхны өрнөлт буй болсон байна, хуурмаг Манж улсыг байгуулсны дараа, япончуудаас “Таван угсаатан хамт найрамдах” уриаг дурдаж, япон, манж, хятад, солонгос хийгээд монгол таван үндэс-тэн хамтаар найрамдахыг сурталчлав. Үүнд япончуудаас монгол үндэстэн бол таван угсаатны дундах хамгийн хоцронгуй угсаатан хэмээн үзэж, “Таван угсаатан хамт найрамдах” харалтыг



Иргэн улсын 1932-1945 оны сонин сэтгүүл хэдийгээр улс төрийн чанараар чанга байсан боловч улс төрийн ухуулгаас гадна монгол үндэстнийг хэрхэн хөгжүүлэх, Монголын түүх шашдир утга соёл, шинжлэх ухаан шинэ мэдлэг зэрэг агуулгуудыг үлэмж мэдээлэн нийтэлж байжээ. Эдгээр агуулга нь тухайн үеийн монгол орны ард түмэнд шинэ мэдлэг, шинэ үзэл санааг дамжуулан өгч, үүний улмаас ард олны үзэл ухамсрыг зохих хэмжээгээр нөлөөлсөн байна



биелүүлэхэд монгол үндэстнийг сэнхрүүлэн хөгжүүлэх бол чухал урьдач нөхцөл мөн гэж дурдаж гаргажээ⁵. Энэхүү үзлийн жолоодлого доор монгол сонин сэтгүүлд монгол үндэстний соёл боловсныг хөгжүүлэх тухай үлэмж шүүмж зохиол нийтэлж ухуулга хийж, үүний хамтаар бас “Улаан барс” зэрэг зарим монгол сэхээтнүүдийн эрхэлсэн сонин сэтгүүлийг ч зөвшөөрөн дэмжиж байжээ.

Нанжингийн засгийн газар ч цагийг амжин сонин сэтгүүл эрхлэн, Монгол орныг илбэн татаж, гоминданы засгийн тойронд нэгтгэхийг зорьж, “Монгол Төвөдийн долоон өдрийн сэтгүүл”, “Монголын арван өдрийн сэтгүүл” зэрэгт “Монгол үндэстний соёл доройтсоны шалтгаан хийгээд сэргийлэх арга”⁶, “Монгол Төвөдийн залуус сурагч түргэнээ шамдан босвоос зохих учир”⁷ мэтийн шүүмж зохиол хааяа нийтэлж байв. Нөгөө талаар “Очир тамын доор, нимгэн мөсний дээр амьдарч бүхий гамшигтай, түгшүүртэй” монгол тоотноо дуудан сэрээж, “Хэдэн зуун түмэн ард олноо эрх тэгшийн оронд хүргүүлж, бүрэн ардын засаг засралыг олгуулах”-ын төлөө монголын сэхээрсэн залуучууд ба дээд давхаргатан жич давшсан хүмүүс тохиол бүхнийг ашиглан сонин сэтгүүл эрхэлж, үндэстнээ хүчирхэгжүүлэх арга замыг эрэлхийлж, ард угсаагаа мандуулах тухай сурталчлан ухуулж байв⁸.

Энэхүү цаг үеийн Монголоо мандуулах үзлийн тухай сонин сэтгүүл дэх ухуулга нь хятад үндсэн онцлог илэрч буй. Нэгд, тоо хэмжээ олон. Хуурмаг Манжийн харьяанд эрхэлж байсан “Монгол сэтгүүл”, “Монгол шинэ сэтгүүл”, ганц дугаар хэвлэгдсэн “Залуусын толь”, “Хөх туг” сонин, “Их Хөх туг” сэтгүүл, Кайлүүд байсан монгол утгын

сургаал хурлын “Улаан барс” сэтгүүл, Гоминданы Нанжингийн засгийн харьяанд эрхэлж байсан “Монгол, Төвдийн долоон өдрийн сэтгүүл”, “Монгол, Төвдийн сарын сэтгүүл”, Нанжингийн Монгол, Төвдийн сургуулийн сурагчийн сэтгүүл “Ирээдүйн монгол”, Хөх хотод хэвлэгдэж байсан “Монголын газарч”, “Зах хязгаарын чимээ нэвтрүүлэх сэтгүүл”, Чуулалт хаалганд хэвлэж байсан “Дахин мандсан монголын чимээ”, “Мандах монгол”, монгол залуус хийгээд сурагчдын эрхэлж байсан “Язгууртан улс”, “Манхны хонх”, “Шинэ монгол”, “Хүчлэн зориглох сарын сэтгүүл” зэрэг олон сонин сэтгүүл цөм үлэмж олон шүүмж зохиол нийтлэн ухуулж байжээ. Хоёрт, ухуулга нь нэлээд гүнзгий бөгөөд системтэй. Эдгээр сонин сэтгүүлийн ухуулга нь нэлээд адилавартай байж, хураангуйлбал доорх мэт хэдэн тал байдаг. (1). Монголоо хөгжүүлэн мандуулахын бачим тулгам чанарыг ухуулсан, (2). Монголын доройтсон шалтгааныг илрүүлсэн, (3). Монголоо мандуулах арга замыг ухуулсан. Гуравт, загвар хэлбэр нь олон. Шүүмж өгүүллээр ухуулж байснаас гадна шүлэг дууллын загвар хэлбэрээр ч байсан байна. Жишээлбэл, “Ирээдүйн монгол” сэтгүүлийн хорин долдугаар хугацаанд нийтэлсэн “Монголоо мандуулъя” гэх шүлэг, “Хөх туг” сонинд нийтэлсэн “Босож хүчжүүлэе хэмээх дуулал”, “Хөх Монголын гүйлсэн цэцэг” гэх шүлэг, “Монгол залуусын өндийн босох дуу” гэх дуу, “Улаан барс” сэтгүүлд нийтэлсэн “Гашууны доторх тэлчлэгч хэмээх үлгэр”, эдгээр ухуулга нь анх соёлж байсан Монголоо хөгжүүлэх үзэл ухамсрыг нэн их чангатгаж, улам их хэмжээнд түгээмэлжүүлсэн байна.

2. *Үндэстний итгэл зоригийг хөвчилсөн.* Эзэн богд Чингис хаан

хийгээд Их Юань улсын үеийн түүхийг танилцуулах нь мөн тэр цаг үеийн сонин сэтгүүлийн чухал нэгэн бүлгийн агуулга болж байжээ. “Хөх туг” сонины хорин дөрөвдүгээр дугаараас эхлэн тусгай бүлэг гаргаж “Их Юань улсын мандсан төрийн хөх судар”-ыг үргэлжлүүлэн нийтэлж байжээ. Үүнээс гадна “Хөх туг” сонинд “Өвөг Чингис хаанаа санах нь их монгол угсаагаа баярлалтай учир” (Долоо дахь дугаарын дөрөв дэх нүүрт), “Өвөг Чингисийн тахилгыг үүтгэгч ихээр тахисан нь”, “Чингис хааны мэндэлсэн өдөр чин үнэнээр тахисан нь” (Арав дахь дугаарын хоёрдугаар нүүрт) гэх мэдээлэл, “Дээд өвөг Богд Чингис хаан мэндэлснээс дэлхий дахиныг эзлэн тогтоосон магтаалын шүлэг” (Арав дахь дугаарын долдугаар нүүрт), “Манай монгол эрхгүй дахин мандаж болохыг магад урьдчилан бодон олсон нь” (Арав дахь дугаарын арваннэгдүгээр нүүрт) зэрэг зохиол мэдээлэл нийтэлж, Богд Чингис хаан хийгээд Их Юань улсын түүхийн тухай агуулга үлэмж нийтэлж байсан. Жишээлбэл, “Ирээдүйн монгол” сэтгүүлийн хорин найм дахь дугаарт “Юанийн төрийн хөгжин мандсан хийгээд цэргийн гавьяа”, гучин нэг дэх дугаарт “Богд Чингис хааны цадиг” зэрэг зохиол нийтэлж байв. Үүнд Чингис хааны гавьяа зүтгэлийг танилцуулах, Их Юань улсын хөгжин бадарсан түүхийн тухай нарийн танилцуулга хийхээр дамжин өргөн олон монголчуудад өөрийн үндэстний түүх гарлыг ойлгуулан суралцуулж, үндэстний омогшил сэтгэлгээ болон итгэл зоригийг хөвчилсөн байна.

3. *Нийгэм амьдралын шинэ үзэл танилтыг буй болгосон.* Тэр цаг үеийн сонин сэтгүүлд Монголыг соён гэгээрүүлэх үзлийн ухуулгын тойронд бас монголчуудын амьдралын дундах болхи бүдүүлэг мунхаг дадал зуршил

хийгээд ажилгүй залхуу зэрэг архаг гэмийг илчлэн шүүмжилж олон талын шинэ мэдээ, шинэ үзэл танилтыг ухуулж байжээ.

(1) Эрүүл хамгааллыг эрхэмлэж ариун цэвэр амьдрах үзлийг ухуулсан. “Эрүүл хамгааллын нөхцөл маш барагтайгаас болж Монголын хүн ам их хэмжээгээр хасагдаж, нүүдэл малжил хийж байгаа монгол айлд зөвхөн дөрвөөс таван хүн амтай байдаг”⁹. Амьдралын дунд ариун цэврийг эрхэмлэхгүйгээс болж, монгол оронд олон зүйлийн өвчин эмгэг дэлгэрч байжээ. Энэхүү байдалд зориулж тухайн үеийн сонин сэтгүүл дээр ардын дундах ариун цэврийг эрхэмлэхгүй заншлыг шүүмжилж, өвчин эмгэгийг сэргийлэх эрүүл хамгааллын мэдлэгийг байнга дамжуулан дөхөмжүүлж байв. Жишээлбэл, “Хөх туг” сонинд нийтэлсэн “Монгол ард угсаатныг дахин сайжруулъя хэмээвээс, урьдчилан түүн дээр нь хор хөнөөл болж байх өвчний үндсийг устган арилгах хэрэгтэй нь” гэх зохиолд өнгөрсний хүчирхэг их байсан монгол үндэстэн одоо ядуу зүдүү өвчин эмгэгт дарлагдаж нэгэнт мөхлийн хэмжээнд хүрчээ. Үндэстнээ дахин мандуулах гэвэл эрхбиш сургаал хүмүүжлийг түгээмэлжүүлж, хүмүүсийг хамаа бүхий мэдлэгтэй болгох хэрэгтэй гэж тодорхой зааж гаргасан байна. “Хөх туг” сонины эрүүл ба гэр зуурх хийгээд биеийн хүмүүжлийн хүснэг хийх тусгай бүлэгт хугацаа болгонд цөм эрүүл хамгааллын тухай нэгээс хоёр зохиол нийтэлж байв. Жишээлбэл, 17 дахь дугаарт “Хортой шиг идшийг сэргийлэх нь”, 19 дэх дугаарт “Эх болсон хүний хүүхдийн идэж уух арван зүйлийн зохистой зүйл”, 21 дэх дугаарт “Хувцас хунарыг угаан цэвэрлэвээс зохих манай монгол хүн”, 22 дахь дугаарт “Гэр тэнхимийн эрүүл хамгаалал”, “Халуун

наран дор хатуу чийрэг болох нь”, 23 дахь дугаарт “Гэдэсний эрүүл хамгаалахуй санаа тавигчид гэр гадна адилаар идээ ундааныг болгоомжлох нь” гэх зэрэг олон зохиол нийтэлж, эрүүл хамгаалал, эмнэлгийн ухааны ерийн мэдлэгийг ухуулж байв. Эдгээрээс гадна “Монгол, Төвөдийн долоон өдрийн сэтгүүл”-ийн биологи эрүүл хамгааллын ерийн мэдлэгийн тухай асуун хариулах нь гэх тусгай булан, “Шинэ монгол” сэтгүүлийн ерийн мэдэл булан, “Их Хөх туг” сэтгүүлийн “Гэр тэнхимийн эрүүлийг хамгаалах хүснэгт” хийгээд “Тэнхлүүнийг хамгаалах ерийн мэдэл” хоёр булан, “Улаан барс” сэтгүүлийн эрүүл хамгаалал булан зэрэг ч эрүүл хамгааллын тухай олон мэдлэг дамжуулж байв.

(2). Хуучны муу дадал зуршлыг тэвчиж, шинжлэх ухаанчаар амьдрахыг сурталчилсан. Тухайн үеийн монгол оронд ажилгүй залхуу болон мухар бишрэл ч түгээмэл оршиж байсан нийгмийн архаг гэм болно. “Монгол сэтгүүл”-ийн наймдугаар дэвтэрт “Залхууран осолдохыг цээрлэх шүүмжлэл”, есдүгээр дэвтэрт “Залхууг цээрлэх нь”, аравдугаар дэвтэрт “Худалч хийгээд залхууг цээрлэх нь”, “Хөх туг” сонины арван нэгдүгээр дугаарт “Алжуу хүний үлгэр”, 23 дугаар дугаарын зургаадугаар нүүрт “Зүдгүүрийн дотроос жаргалыг эр” зэрэг шүүмж зохиолд ажилгүй залхууг илчлэн шүүмжилж, ажилч борогчуудын илүү хөдөлмөрлөхийг сурталчилжээ. “Хөх туг” сонины арван дөрөв дүгээр дугаарт “Мунхаг бишрэлийг устгахуй дор нялх багаас эхэлмой”, арван найм дахь дугаарт “Шинжлэх сургаал хийгээд мунхаг бишрэл”, “Ирээдүйн монгол” сэтгүүлийн арван долдугаар дугаарт “Манай монголчуудын мухар бишрэлийг хэрхэн арилгах нь” зэрэг зохиолд тухайн үеийн монголчуудын дунд оршиж байсан му-

хар бишрэлийн үзэгдлийг шүүмжилжээ. Үүнээс гадна “Хөх туг” сэтгүүлийн хорьдугаар дугаарт “Хуучин дадлаа гээж хандлага зорилтыг шинэ замд жишихүй нь” хорин нэгдүгээр дугаарт “Ураг бололцох хуучин дүрмийг нэг мөсөн устгаж эдүгээх шинэ цагийн ёсыг эрхэмлэн дагаж халан сайжруулах өчүүхэн эрмэлзэл”, хорин найм дугаар дугаарт “Ураг бололцох хуучин дүрмийг халан сайжруулах хэмээх эрмэлзэл”, гучин гуравдугаар дугаарт “Татвар эм бологчдын хөнөөл”, дөчин тавдугаар дугаарт “Шинжлэх ухаанаар хатуу тэнхлүүн шинэ амьдралыг хийх хэрэгтэй”, тавьдугаар дугаарт “Хуучин ёсоор ураг холбохыг халан шинэтгэхийг хүсэн эрмэлзэх нь”, тавин тавдугаар дугаарт “Хорчин баруун гарын хойд хошууны ураг барилдах хуучин ёсыг халан сайжруулахаар тунхагласан нь”, тавин зургаадугаар дугаарт “Манай Монголын угсаатны ураг барилдах хийгээд Япон улсын ардын ураг барилдах ялгавар”, “Шинэ цагийн ухаан мэдэл”, “Урьдын цог жавхлангаа эрхлээд удаарсан муу дадлыг халах шүүмжлэл” гэх зэрэг олон зохиолд хуучны муу заншлыг шүүмжлэн, шинэ амьдрахуйн үзэлт танилтыг сурталчлан ухуулж байв. Эдгээрийн дунд зарим зохиол нь бас манай монгол хүний өөрөө бичсэн зохиол байж, “Хөх туг” сонины уншигчдаас ирсэн эх бичгийн хүснэгт хийх бүлэгт гарч байжээ. Энэ нь ч мөн тухайн үеийн монголчуудын дунд хуучин муу дадал зуршлыг халан сайжруулах одоогийн боловсон шинэ үзэл ухамсар чангарсныг харуулж байна.

Дээрх танилцуулсан зохиолд ойр орчин үеийн монголын нийгмийн ядуу хоцронгуй, өвчин тахал, мухар бишрэлийн түүхт нөхцөл доор, нэг бүлэг соён гэгээрсэн бичигтэн сэхээтнүүдээс үндэстэн угсаатнаа хөгжүүлэн мандуулах

гэвэл эрхбиш үндэстний бие махбодоос үзэл ухамсарт хүртэлх ерөнхий уур чанарыг дээшлүүлэх хэрэгтэй гэснийг таньж олсон байжээ. Үүний улмаас сонин сэтгүүл ном хэвлэл зэрэг зуучлуурыг ашиглан өдөр тутмын амьдралын ариун цэвэр эрүүл хамгаалал, биеийн тамирын боловсрол, гэрийн сургаал зэрэг одоогийн боловсон үзэлт танилтыг сурталчлан ухуулж, цаашид монголчуудын үзэлт танилтыг хувируулж, үндэстэн угсаатнаа хөгжүүлэн мандуулах зорилтыг биелүүлэхээр чармайж байжээ. Ардын дунд ч гэсэн үзэл ухамсрын талд зохих хувиралт гарч, хуучин дадал хийгээд мухар бишрэлийн хүлээснээс мултарч, одоогийн эмнэлэг хийгээд эрүүл хамгааллын үзэлт танилтыг хүлээн авч, амьдралын шинэ дадал шинэ ухамсар буй болж эхэлсэн байна¹⁰. “Алив одоогийн арга барилыг ашиглан монгол хүний бие боловсрол хийгээд хүн амын амьдралын тусад их хэмжээний ажил хийжээ. Үүнд хамаг чухал нь ариун цэвэр эрүүл хамгааллын олон нийтийн үзэл ухамсар нэгэнт монголчуудын дунд буй болж, өнгөрсөнтэй харьцуулбал шийдвэрт ач холбогдол бүхий үйлдэл гарсан байна”¹¹.

Гурав. Үндэстний соёлын дамжуулга дахь үр нөлөө. Ойр үеийн монгол соёлын хөгжилт нь сурган хүмүүжлийн хөгжилт хийгээд сонин сэтгүүл ном хэвлэлийн хөгжил-төөс салж чадахгүй. Ойр үеийн сурган хүмүүжил хийгээд ном хэвлэлийн хөгжилтөөс монголчуудын дунд үсэг таньж бичиг мэддэг хүний тоо олон болж, бичигтэн соёлтны эгнээ улам бузгайрсан байна. Сонин сэтгүүлийн хөгжилт нь үндэстний соёлын уламжлан дэлгэрүүлэх нэн их орон зайг олсон байна. Нэг талаар сонин сэтгүүл нь тухайн үеийн бичигтэн соёлтны зохиол бүтээл нийтэлдэг тавцан болж байсан.

Тэр үеийн монгол үндэстний бичигтэн соёлтноос үндэстнийхээ бичиг соёлыг хөгжүүлэхийн тусад олон шүүмж зохиол бичиж сонин сэтгүүлд нийтэлж байсан юм. Үүнд агуулгын талаар үг хэл үсэг бичиг, үндэстний соёл сурган хүмүүжил, зан заншил, түүх судар, шинжлэх ухаан, ерийн мэдлэг зэрэг нийгэм амьдралын олон талыг хамарч байжээ. Нөгөө талаар сонин сэтгүүл нь соёлын ачаалагч бие болсны хувьд үндэстний соёлыг улам өргөн хэмжээгээр урт хугацаа уламжлан дэлгэрүүлэхэд чухал үйлдэл үзүүлж байсан нь дамжиггүй юм.

1. *Утга зохиолын хөгжилтийг ахиулсан.* Иргэн улсын 1932-1945 оны хооронд эрхэлж байсан монгол сонин сэтгүүлийн чухал нэг үүрэг бол утга соёлын үйлсийг хөгжүүлэхээр дамжуулж монгол угсаатнаа соёлжуулан гэгээрүүлэх болно. Төвөг будилаантай нийгмийн орчинд адил бусын нам бүлэг, эвлэл холбоо, улс төрийн хүчин, эсвэл хувь хүн сонин сэтгүүл эрхэлсэн нь маш чанга нийгмийн үзэл ухамсрыг эзэмших зорилготой юм. Цаашилбал, монгол хүнийг өдөөн татах гэхээр ч “Утга соёлыг хөгжүүлэх” гэх тухайн монголчуудын давчигдан хүлээж байгаа үзэл ухамсрыг ашиглахгүй байхын аргагүй. Иймээс 1945 он хүртэлх монгол сонин сэтгүүлд соён гэгээрүүлэх утга соёлын агуулга тун их хувийн жинтэй байжээ¹². Иймээс сонин сэтгүүл нь тухайн үеийн монгол бичигтний зохиол бүтээл нийтэлдэг чухал тавцан байсан юм.

“Улаан барс” сэтгүүл нь тухайн үеийн монголчуудын дунд чухал байр суурьтай байсан монгол сэтгүүл болсны хувьд “Утга соёлоор монгол угсаатнаа тэтгэн тэнхрүүлэх” зорилготой байжээ. Бөххишиг “Хурлын гишүүнд өгсөн захидал”-даа “Чи бидний зохиосон муу боловч, манай муу зохиолтоор бусдын сайн зохиолтыг өдөөн гаргаж чадваас

даруй ч бидний үүрэг тушаал гүйцэх болой, ийнхүү муу нь сайнаа өдөөн гаргаж чадсаар сая нэгэн улсын утга соёл бадарч чадах бус уу?”¹³ гэж, бас “Шүлэг дуу, энэ нь ганц толгой холбосон зохиолын төдий биш, эрхбиш хүний санаанд суумаар гүн утгатай байх хэрэгтэй”¹⁴ гэж зохиол бүтээлийг ухамсартай өдөөж байсан юм. Цаашид “Монгол утгын соёлын хурал” нь бас үлгэрийн зохиол элсэж шан хүртээх аргаар зохиолчийг өдөөж байсан үзэгдэл ч буй. Өнөөдрийн бидний сайн мэддэг нэрт зохиолчдын сонгодог зохиол бүтээлүүд “Улаан барс” сэтгүүлд үлэмж нийтлүүлж байсан юм. Жишээлбэл, Сайнцонгын “Хүн хэмээгчийн утга”, “Лиү Пэн Шан уул”, Ринченхоролын “Гашууны доторх дэлчлэгч хэмээх үлгэр”, Эрдэнэтогтохын “Хөх Монголын гүйлсэн цэцэг”, “Ирээдүйн Монгол”, Буяндэлгэрийн “Үйлийн үр”, “Малын хүн”, “Монгол хүний буянаар”, Эрдэмтөгсийн “Эдүгээгийн залуус”, Мөнгөн-Өлзийн “Адуучны дуу” зэрэг зохиолууд цөм “Улаан барс” сэтгүүлд адил бус хугацаанд нийтлэгдэж байв.

Тухайн үед чухал нөлөө үзүүлж байсан хуурмаг Манжийн харьяаны хамгийн том монгол хэлний сонин “Хөх туг” сонин ч “Утга урны хүснэгт”, “Уншигчдаас ирсэн эх бичгийн хүснэгт” гэж тусгай булан гаргаж, монголчуудын утга зохиолын бүтээлүүдийг нийтэлж байжээ. Зөвхөн 1941 онд бараг 300 илүү зохиолыг нийтэлсэн байдаг¹⁵. Б.Гэрэлт “...“Хөх туг” сонин дээр шүлэг өгүүллэг найруулга шүүмжийн зохиол нийтлэгдсэн хүмүүс бараг зуу наяд бүртгэгдэж байна...” гэж мэдээлэв¹⁶.

Тус цаг үеийн утга зохиол үндэстнээ мандуулах сэдвийн зохиолоор гол урсгал болгож, шүлэг дуу, найруулал, өгүүллэг, шүүмж зэрэг зохиолын тигүүд үлэмж хөгжилттэй байжээ. Дурдууштай

нь хүүхдийн утга зохиол хийгээд шинжлэх ухааны ерийн мэдлэгийн сул зохиол ч нэлээд хөгжилттэй байжээ. Үүний хамт бас ардын аман зохиолын төрөл хэлбэр ч олон нийтлэгдэж байжээ. Жишээлбэл, “Монгол сэтгүүл”, “Монгол шинэ сэтгүүл”, “Хөх туг” сонин, “Ирээдүйн монгол”, “Улаан барс”, “Утга соёлын тусгай дармал” зэрэг сонин сэтгүүлд хааяа ардын дуу, бага үлгэр, дүрэмт үгс, оньсого үгс, хавт үгс, ерөөл магтаал, холбоо зэрэг агуулгуудыг олон нийтэлж байсан юм.

2. *Үг хэл үсэг бичгийн хөгжилтийг ахиулсан.* Иргэн улсын үеийн монгол сонин сэтгүүл нь тухайн үеийн монгол хэл үсэг бичгийн хөгжилтөд ч чухал нөлөө үзүүлсэн юм. Нэг талаар сонин сэтгүүл дэх хэний хэрэглээ нь тухайн нийгмийн үг хэл үсэг бичгийн нэгдэн хөгжихөд чухал жолоодох үйлдэл хийгээд түгээмэлжүүлэх үйлдэл үзүүлдэг юм. Нөгөө талаар тухайн үеийн сонин сэтгүүлд үг хэл үсэг бичгийг нэгтгэх, шинэ нэрийдэл шинэ хэллэгийг хянан дүрэмжүүлэх зэрэг ажиллагааг бага бус өрнүүлсэн байжээ. Энэ нь мөн тухайн үеийн монгол хэл үсэг бичгийн хөгжихөд чухал үйлдэл үзүүлсэн нь дамжиггүй.

Хуурмаг Манжийн эрхэлж байсан монгол сонин “Хөх туг” сонинд үг хэл үсэг бичгийн тухай өгүүлэл зохиол цаашлаад тайлбар толь зэрэг олон нийтэлж байсан зөндөө харагддаг. Жишээлбэл, арван наймдугаар дугаарт “Монгол утгын нөхцөл үсгийн тайлбар”, дөч есдүгээр дугаарт “Монгол үгийн уг утгын тухай”, далан тав дахь дугаарт “Газрын үгийг харилцан танилцуулах нь” зэрэг монгол үг үсгийн тухай өгүүлэн тоочсон зохиол байдаг. Үүнээс гадна “Монгол үсгийн шинэ толь”, “Монгол утгын сургаал хурлаас тогтоосон шинэ нэрс үгийн толь”, “Сэтгүүл дор хэрэглэх үгс” зэргийг үргэлжлэн нийтэлж байжээ.

Нэн дурдууштай нь монгол утгын сургаал хурлаас шинэ нэр томъёог орчуулан дүрэмжүүлэх ажлыг зохион байгуулалттай нарийн нямбай явагдуулж, “Улаан барс” сэтгүүлд нийтэлж байжээ. “Улаан барс” сэтгүүлийн дөрөв дэх дугаарт “Шинэ нэр томъёог орчуулан тогтоосноо олноо илтгэсэн” үгсдээ: “...Энэхүү шинэ нэрсийг тус хурлын гол хэрэг мэдэгч Бөхшиг, хурлын гишүүн Чалунга, Үнэнзаяат хоёртой гурвуулаа орчуулж гаргаад, хурлын удирдагч багш Ро авгайгаас залруулан тогтсон нь, энэ нь бичиг судар орчуулахад маш чухал хэрэгтэйн дээр тус хурлын олон гишүүн найдам хэрэглэхэд давтай сайныг олохгүй гачигдсан бүхий нэрсийг сонгож хэдэн арвыг орчуулсан бүлгээ. ... Юунаас урьд монголд хуучин байх нэрс буюу одоод олон хүн хэрэглэж бүхий нэрсийг голчлон авч хамгийн зохимой хэмээсэн нэгийг сонгож гарган тогтоов” гэж нийтэлжээ.

“Улаан барс” сэтгүүлээс шинэ нэр үгийг орчуулан дүрэмжүүлэхдээ урьдаар тогтоогүй нэр үгээ сүүлд нийтэлж, нийгэмд өргөн хэмжээгээр санал хурааж, нэн зүй зохистой олон нийтэд мэдрэгдсэнийг сонгож тогтоодог байжээ. Жишээлбэл, шинээр тогтоохыг хүлээж байх нэр томъёо: “赤道-chi dao”, “热带-re dai”, “寒带-han dai”, “环境-huan jing”, “潮流-chao liu”, “细胞-xi bao”, “经度-jing du”, “艺术-yi shu”. Ингээд нэгэнт шинээр тогтоочихсоныг нь дахин сэтгүүлд нийтэлж байв. Жишээлбэл, Ази тив 亚细亚洲-ya xi ya zhou, эрүүлийг хамгаалах 卫生-wei sheng, эрх чөлөө 自由-zi you, нисэх тэрэг 飞机-fei ji, төлөөлөгч 代表-dai biao, газрын бөмбөрцөг 地球-di qui, сурган

хүмүүжил 教育-jiao yu, цахилгаан үг 电话-dian hua зэрэг. “Улаан барс” сэтгүүлийн энэхүү ажиллагаа нь 1936 оноос эхлүүлж 1941 он болтол үргэлжилж, нийт таван зуу илүү үг үсгийг орчуулан дүрэмжүүлжээ. Тус ажилд оролцож байсан хүн нь ч анхны дөрвөн хүн байснаас сүүлд нь долоон хүн болсон байна. Энэхүү ажиллагаа нь тухайн үеийн монгол үндэстний дунд шинээр үүсч байгаа шинэ соёл болон хэрэг бодисыг ойлгуулахын дагууд, монгол хэлний үгсийн санг баяжуулахад цөм баларшгүй гавьяа зүтгэл гаргасан байна.

3. Шинжлэх ухаан соёл мэдлэгийн хөгжилтийг ахиулсан. Энэхүү цаг үеийн сонин сэтгүүлийн бас нэгэн чухал үр нөлөө гэвэл даруй монгол оронд шинжлэх ухааны мэдлэгийг дамжуулан тухайн үеийн монголчуудад одоогийн шинэ соёл боловсонтой танилцах завшааныг олгосон байна. Энэ нь тухайн үеийн “Хөх туг” сонин, “Улаан барс” сэтгүүл хийгээд монгол залуусын эрхэлж байсан сонин сэтгүүлд онцгойлон товойм илрэлтэй юм.

“Хөх туг” сонинд хүүхэд багачуудад гол чиглүүлж “Хүүхдийн хөх туг” гэх тусгай булан гаргаж, голдуу эл зүйлийн шинжлэх ухааны мэдлэгийг танилцуулан ухуулж байв. Үүнд одон орон, газрын зүйгээс цахилгаан тоног төхөөрөмж, цэрэг зэвсгээс хүний биеийн бүтэц бүрэлдэц зэрэг олон агуулгыг хамарч байжээ. “Улаан барс” сэтгүүлд “Ерийн мэдэл”, “Газрын зүй”, “Эрүүл хамгаалал”, “Шинжил ухаан” зэрэг булан гаргаж шинжлэх ухааны шинэ мэдлэгүүдийг нийтэлж байжээ. Жишээлбэл, Улаан барс” сэтгүүлийн аравдугаар хугацааны гуравдугаар тэмдгийн “Шинжил ухаан” буланд “Цэрэгт хэрэглэх нисэх тэрэгний зүйл” гэх зохиолд цэрэгт хэрэглэх зургаан зүйлийн нисэх

тэргийг танилцуулахдаа түүний үүрэг хариуцлага, байлдах хэлбэр, хэрэглэх арга зэргийг нарийн тайлбарлажээ. Монгол залуусын эрхэлж байсан “Шинэ монгол” хэмээх сэтгүүлийн ерийн мэдлийн булангийн “Газар нь биднийг татаж амуй” гэх зохиолд газрын бөмбөрцгийн татах хүчний тухай нарийн тайлбарлан танилцуулж, “Бороо, үүл, манан, цас, мөндөр, хяруу, шүүдэр” гэх зохиолд бороо, үүл, манан, цас, мөндөр, хяруу, шүүдэр зэрэг байгалийн цаг уурын үзэгдлийн буй болох явцыг маш ойлгомжтой сайн танилцуулсан байдаг. Эдгээрээс гадна “Дахин мандсан монголын чимээ”, “Мандах монгол” зэрэг сэтгүүлд бас шинжлэх ухааны мэдлэг танилцуулсан булан буюу зохиол нийтэлж байжээ.

Дөрөв. Үндэстний соёлын солилцоон дахь үр нөлөө. Сонин сэтгүүл нь соёлын ачаалагч болсны хувьд соёлыг эл газарт дамжуулан дэлгэрүүлэхийн хамт мөн эл газар орны соёлын хоорондох солилцоог ахиулдаг юм. Үүнд ойр орчин үеийн монгол орон нь ядуу хоцронгуй байснаас гадна бас соёлын орчин маш түгжмэл байж, гадаад орчны сураг занги хийгээд соёлын дамжуулгыг хүртэхэд их хүчир байжээ. Сонин сэтгүүлийн их хэмжээгээр тархахыг дагалдан эл газрын сураг занги хийгээд соёл мэдлэг ихээр дамжигдах, энэ нь монгол оронд авч хэвлэл соёлын солилцоог ихээр ахиулж чадсан байна.

1. *Өвөр Монголын зүүн баруун орны соёлын солилцоог ахиулсан.* Чин улсын сүүлчийн үеэс эхлэн орон нутгийн хуваарилалтаас болж монгол орныг зүүн баруун орон хувааж, “Зүүн монгол”, “Баруун монгол” гэж хуваах үзэлт аажмаар бүрэлдсэн байжээ. XX зууны эхнээс япончуудын нэвчилтийн ажиллагаанаас эхлэн өвөр монголын

зүүн орныг хагацуулан авч хуурмаг Манж улсыг байгуулсан нь нэн ч зүүн баруун орны хоорондох харилцааг тастсан байжээ. 1937 онд япон эзэрхэг түрэмгийтнээс өвөр монголын баруун орныг эзэлсний сүүлээр хэдийгээр монгол хязгаарын засгийг тэтгэн байгуулсан боловч, хуурмаг Манж улстай адилавар болгохыг зорьж, өвөр монголын зүүн орноор баруун орныг нөлөөлүүлэх бодлого авч, зүүн баруун орны хоорондох харилцааг чангатгасан байжээ. Үүний илрэл нь голдуу зүүн баруун орны улс төр засаг захиргааны харилцаа, сурган хүмүүжлийн харилцаанаас гадна даруй сонин сэтгүүл дэх мэдээлэл уламжлал болно.

Сонин сэтгүүлийн мэдээлэл уламжлал нь голдуу хуурмаг Манжийн “Хөх туг” сонин дээрх баруун орны тухай мэдээлэл болно. “Хөх туг” сонины 7, 8, 9 дүгээр хугацаанд “Баруун монголын чимээ” гэх тусгай булан эрхэлж, баруун монголын эл талын сураг чимээг уламжилж байсан. Аравдугаар хугацаанаас эхлэн баруун монголын тухай хэсэг бусаг мэдээлэл хийж байжээ. “Хөх туг” сонин нийт 178 хугацаа хэвлэгдэж, түүний дунд 48 хугацааны сонинд 120 гаруй зурвас баруун монголын мэдээлэл хийсэн байдаг¹⁷. Эдгээр мэдээлэл нь баруун монгол орны улс төр, аж ахуй, соёл сурган хүмүүжил, ламын шашин зэрэг олон талын агуулгыг хамарч байжээ. Энэ нь зүүн монголын монголчуудаас баруун монголын байдлыг ойлгон мэдэхэд чухал үйлдэл үзүүлсэн байдаг. Үүнээс гадна бас баруун монголын зохиолчдын ирүүлсэн зохиол бүтээлийг үлэмж нийтэлж байсан юм. Жишээлбэл, “Хөх туг” сонинд нийтэлсэн баруун монголын Батжавын зохиол “Уншигч олон авгай нараа”, дөрвөд хошууны Сөлтунгаагийн чимээ “Гэрийн тэжээврийн тахилгыг маш хөгжилтэй-

гээр хийсэн нь”, дотоод монголын баруун Сөнид хошууны багачуудын сургуулийн сурагч Баянтунгалагийн зохиол “Монгол залуусын урагш чармайлцах дуу”, цахар чуулганы Шулуун хөх хошууны Баясгалангийн “Хавар”, “Одны сүрэг”, “Найртай хүндээ илгээсэн найрамдлын шүлэг”, “Урагш чармайх шүлэг”, “Хөх тугийн магтаал”, “Журамт гэргийг нэхэмжлэн санаж журмын ёсыг гүйцэтгэсэн зузаан санаа” зэрэг зохиолууд нь цөм баруун монголын зохиолч буюу уншигчийн тухайн үеийн баруун монголын монголчуудын амьдрал соёл орчныг тольдуулсан бүтээл байжээ. “Хөх туг” сонин ч тухайн үед баруун монголын эл дэс давхаргын байгууллага нэгж хийгээд сүм хийд сургууль зэрэгт төлбөргүйгээр түгээн өгч байсан нь мөн л баруун монголын монголчуудад зүүн монголын байдлыг ойлгон таньж, зүүн барууны соёлын солилцоог цаашид ахиулсан байна.

2. Хятад монгол соёлын солилцоог ахиулсан. Хятад монгол хоёр үндэстний соёлын солилцоо бол аль эртнээс явагдсаар ирсэн байжээ. Гэхдээ эрт үеийн монгол хятад соёлын солилцоо нь голдуу холилдон суурьшсан ардын дундах харилцааны дунд, тогтсон хугацаатай явагдах монгол хятад арилжааны дунд төвлөрөн явагдаж байсан юм. Үүнд ХХ зууны эхний үед монгол орны сурган хүмүүжлийн хөгжилтийг дагалдан дотоод орны хятад соёл аажмаар монгол оронд дамжигдсан байна. ХХ зууны хориод оны үе болоход ном бичиг, сонин сэтгүүлийн үйлсийн хөгжилтийг дагалдан монгол хятад соёлын солилцоо нь өдөр ирэх бүр нягтрав.

1932-1945 оны хоорондох сонин сэтгүүлийн дамжуулга нь монгол хятад соёлын солилцоог улам нэг алхам хөгжүүлжээ. Энэ нь доорх гурван талд

илэрч байдаг. Нэгд, сонин сэтгүүлийн агуулгын талаас ажиглаж үзвэл, энэ цаг үеийн сонин сэтгүүлд хятад үндэстний утга зохиолыг монгол хэлэнд орчуулан нийтэлсэн зүйл олон харагддаг бөгөөд хятад хэлээр нийтэлсэн зохиол бүтээл ч бага бус байдаг. Жишээлбэл, “Хөх туг” сонинд “Дээлийн эвдэрснийг нөхөж буруугаа санах”, “Ван Шингийн мөст хэвтэх”, “Үхэрийг онож бичиг унших”, “Дөрвөн настайдаа алимыг тавьж өгөх”, “Илүү хэлбээс тусгүй”, “Онгоцыг сийлэн ширийг эрэхүй нь”, “Гован Зүн хөгшин морийг багш болгосон нь” гэх мэтийн хятадын зүйр сэцэн үгийн тухай үлгэр домгуудыг орчуулан нийтэлж байсан. “Ирээдүйн монгол” сэтгүүлийн хятад хэлний хэсэгт “今后蒙汉青年之携手-jin hou meng han qing nian zhi xie shou”, “复兴蒙古-fu xing meng gu”, “雲-yun”, “痛心的话-tong xin de hua”, “给一个失学蒙古的青年的信-gei yi ge shi xue meng gu qing nian de xin”, “献给蒙古青年”, “秋叶感怀-qui ye gan hua” зэрэг хятад шүлэг зохиол нийтлэхийн хамт бас монгол үндэстний түүхийн тухай зохиол танилцуулга “秦汉两朝蒙古向西发展情形-qin han liang chao meng gu xiang xi fa zan qing xing” зэргийг нийтлэж байжээ. “Хүчлэн зориглох сарын сэтгүүл”-д бас уран зохиол хийгээд шинэ шүлэг гэх тусгай булан эрхэлж хятад хэлний шүлэг зохиол үлэмж нийтэлж байжээ.

Энэ цаг үеийн сонин сэтгүүлийн зохиогчийн талаас ажиглаж үзвэл монгол сонин сэтгүүлийн зохиол бүтээлүүдийн зохиогч нь монгол зохиогч болох нь гарцаагүй. Гэвч монгол хятад хос хэлний сонин сэтгүүлийн зохиол нь зарим нь монгол зохиогчийн зохиосон хятад шүлэг зохиол байдаг, зарим нь хятад зохиолчийн бичсэн монгол үндэстний хамаатай хятад зохиол байдаг. Монгол хэлнийхний

хэсэгт голдуу хятад хэлний хэсгийн чухал зохиол мэдэгдлээс орчуулсан нь маш илэрхий. Сонин сэтгүүлийн уншигчдын байдлаас ажиглаж үзвэл, монгол хэлний сонин сэтгүүлийн уншигч нь монгол хүн болох нь яриангүй. Гэвч монгол хятад хавсаргасан сонин сэтгүүлийн уншигчид нь монголчуудаас гадна бас хятад үндэстний уншигч бас үзэж ойлгох болдог учраас хятад уншигч бас байж мэднэ. Үүнд тухайн үеийн монгол залуус хийгээд сэхээтнүүд ч монгол хятад хэлний ном зохиол цөм уншиж ойлгодог байсан юм.

3. *Япон, Монголын соёлын солилцоог ахиулсан.* Япончууд зүүн монголыг эзэлж колонийн орон болгохын төлөө аль эртнээс соёлын нэвчилт хийсээр ирсэн юм. Хуурмаг Манж улсыг байгуулагдсаны дараа япончуудаас монгол хүний соёл боловсныг дээшлүүлэхэд нэн өндөр зэргийн соёл болох японы үг хэл хийгээд соёлоор жолоодлого болгох хэрэгтэй гэсэн үзэл санааг дурдаж, япон соёлын тухай ухуулгыг нэн эрчимтэй чангатгасан байж билээ. Японы соёлын ухуулгын гол фронт болсон сонин сэтгүүлийн япон соёлын тухай ухуулга нь голдуу хятад талд төвлөрч байжээ. Нэгд, японы монголыг сэнхрүүлэх төрийн бодлогыг ухуулж байсан. Япончуудын энэхүү төрийн бодлогод голдуу сурган хүмүүжил, эрүүл хамгаалал эм эмнэлэг хийгээд шашин суртахуун зэрэг гурван гол тал байжээ. Тус гурван талын төрийн бодлогын дунд уусан шингэж байгаа японы шинэ үзэл ухамсар, шинэ арга хэмжээ, шинэ сэтгэхүй зэрэг нь сонин сэтгүүл дэх энэхүү гурван талын ухуулгаар дамжин монгол оронд уламжлагдсан байжээ. Хоёрт, японы үг хэл болон уран зохиолыг уламжлан дэлгэрүүлсэн. Японы хэлийг түгээмэлжүүлэх бол япончуудын колонийн сур-

ган хүмүүжил хийх чухал арга хэмжээ байжээ. Үүнд хуурмаг Манжийн эрхэлж байсан монгол сонин сэтгүүл болгонд цөм япон хэл заан сургах тусгай бүлэг тохируулж байсан юм. Үүнээс гадна японы уламжлалт үлгэр домог хийгээд сонгодог зохиол бүтээл, хүүхдийн уран зохиол зэргийг монгол хэлэнд орчуулан олныг нийтэлж байжээ. Гуравт, япон улсын өнгө үзэмж, хувцас засал, зээл гудамж, ардын амьдралын байдал зэргийг үлэмж танилцуулж байсан. Тухайн үеийн хуурмаг Манжийн эрхэлж байсан монгол сонин сэтгүүлийн илэрхий байранд зураг сүүдэртэй танилцуулж байсан нь одоо уншихад ч гэсэн хүмүүсийн анхаарлыг татаж чадмаар ухуулга байсан юм. Эдгээр ухуулга нь хэдийгээр колонийн шинж чанараар чанга байсан ч бусад ч талд япон монголын соёлын солилцоог ахиулсан нь дамжиггүй юм. Нэн ялангуяа тухайн үеийн монголчуудын ухаан мэдлийг нэмэгдүүлж, соёл боловсныг дээшлүүлэхэд үнэнхүү чухал үйлдэл үзүүлснийг үгүйсгэж болохгүй юм.

Эшлэл

- 1 郭庆光：《传播学教程》·中国人民大学出版社·2007年·P198
- 2 陆军参谋本部：《东蒙事情特别号》·1916年·P31-33·转引自广川佐保(Hiroka Saho) [日]：《40年代日本对内蒙古的政策与《青旗报》》·蒙古学信息·第四期
- 3 广川佐保(Hiroka Saho) [日]：《40年代日本对内蒙古的政策与《青旗报》》·蒙古学信息·第四期
- 4 刘映元：《李守信自述》·内蒙古文史资料·第20辑·1985年·P336-348
- 5 广川佐保(Hiroka Saho) [日]：《40年代日本对内蒙古的政策与《青旗报》》·蒙古学信息·第四期
- 6 “Монгол төвдийн долоон өдрийн сэтгүүл”-ийн долдугаар дэвтэр

- ⁷ “Монгол төвдийн долоон өдрийн сэтгүүл”-ийн далан гуравдугаар дэвтэр
- ⁸ Оюун: “Дундад улсын орчин үеийн монгол сонин сэтгүүлийн судлал”, Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо, 2014 он. хуудас 232.
- ⁹ [德] 海西希著 · 吉日嘎拉译 : 《满洲国兴安省蒙古文化变迁研究》(未刊稿) · P68 · 转引自 斯琴巴图 : 《东蒙古殖民地社会与文化的变动》内蒙古大学 · 博士学位论文 · 2013 ..
- ¹⁰ 斯琴巴图 : 《东蒙古殖民地社会与文化的变动》内蒙古大学 · 博士学位论文 · 2013 · P 94 ..
- ¹¹ [德] 海西希著 · 吉日嘎拉译 : 《满洲国兴安省蒙古文化变迁研究》(未刊稿) · P71 · 转引自 斯琴巴图 : 《东蒙古殖民地社会与文化的变动》内蒙古大学 · 博士学位论文 · 2013 ..
- ¹² Отгонбаяр: “Одоо үеийн соён гэгээрүүлэх монгол утга зохиол 1902-1947”, Өвөр монголын их сургууль, доктор цол хамгаалах өгүүлэл. 2009 он. хуудас 100
- ¹³ Мөн тэнд. ху. 108
- ¹⁴ Мөн тэнд. ху. 109
- ¹⁵ Отгонбаяр: “1941 оны “Хөх туг” сонин дээр нийтлэгдсэн утга зохиолын шинжлэл”, “Өвөр монголын их сургууль” эрдэм шинжилгээний сэтгүүл, 2009 оны 3 дугаар хугацаа. хуудас 96.
- ¹⁶ Б.Гэрэлт: “Суугийн ногоо”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998 он, хуудас 4.
- ¹⁷ 斯琴巴图 : 《东蒙古殖民地社会与文化的变动》内蒙古大学 · 博士学位论文 · 2013 · P 156 ..

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гүвви Чанг Гуанг “Мэдээлэл зүй”, Дундад улсын Ардын их сургуулийн хэвлэлийн хороо, 2007, 198 дугаар нүүр /монгол бичгээр/
2. Хирука Саху [Япон], “Дөчөөд оны үе дэх

- японы өвөрмонгол дахь төрийн бодлого ба “Хөх туг сэтгүүл”, Монгол судлалын Сураг занги, дөрөвдүгээр хугацаа.
3. Отгонбаяр. “Одоо үеийн соён гэгээрүүлэх монгол утга зохиол 1902-1947”, Өвөр монголын их сургууль, доктор цол хамгаалах өгүүлэл. 2009.
 4. Отгонбаяр. “1941 оны “Хөх туг” сонин дээр нийтлэгдсэн утга зохиолын шинжлэл”, “Өвөр монголын их сургууль” эрдэм шинжилгээний сэтгүүл, 2009 оны 3 дугаар хугацаа.
 5. Б.Гэрэлт. “Суугийн ногоо”, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998.
 6. Сэцэнбат “Зүүн монголын колонийн орны нийгэм соёлын хувиралт”, Өвөр монголын Их сургуулийн докторын цол хамгаалах өгүүлэл, 2013.
 7. Оюун. “Дундад улсын орчин үеийн монгол сонин сэтгүүлийн судлал”, Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо, 2014.

Summary

The influence of Mongolian newspaper propaganda on Inner Mongolia social culture during 1932-1945 in the period of the Republic of China. All kinds of political forces have used newspapers and magazines to publicize their own political thoughts, to influence and change the people's ideology, to achieve the purpose of consolidating their own political rule. At that time, the publicity and dissemination of newspapers and magazines had a certain impact on the society at that time, such as the formation of a monopoly of the public opinion environment, the people's ideas had a certain change, and even played a certain role in promoting the dissemination and development of national culture. This paper makes a deep and concrete research on the influence of newspaper propaganda on the social culture of Inner Mongolia during 1932-1945.